

**САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ОРЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
Н.ЖАРГАЛМААГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 06

НОМГОН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Гүйцэтгэлийн түвшин		
					Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8

Зорилт 1. "Төсвийн орлогын төсөл боловсруулж, төсвийн төслийг сангийн яаманд хүргүүлэх" зорилтын хүрээнд

	<p>Арга хэмжээ №1.1. Аймгийн 2026 оны төсвийн орлогын төсөл төлөвлөгөөний төслийг боловсруулж, Сангийн яаманд хянуулах</p>	<p>Орлогын төлөвлөгөө боловсруулалтын гүйцэтгэлийн хувь</p>	<p>0%</p>	<p>100%</p>	<p>Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн орлогын төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг олон жилийн динамик судалгаанд үндэслэн бодитой төлөвлөхөөр холбогдох судалгааг боловсруулсан. Төсвийн орлого бүрдүүлэгч байгууллагууд болон сумдын саналыг авах албан бичгүүдийг хүргүүлж, холбогдох саналуудыг нэгтгэх ажлыг зохион байгуулж байна.</p>	<p>2025.01.01-2025.06.30</p>	<p>100</p>
1.	<p>Дэд арга хэмжээ – 1.1.1: Татварын нэр төрөл бүрд судалгаа, шинжилгээ хийх</p>	<p>Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь</p>	<p>0%</p>	<p>40%</p>	<p>Аймгийн 20 сумын 2021-2024 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд динамик шинжилгээ хийж, орлогын биелэлтэд нөлөөлсөн гол хүчин зүйлс, шалтгаануудыг тодорхойлсон. Шинжилгээний үр дүнд зарим нэр төрлийн татварын орлого тасралттай байгааг илрүүлж, нэр төрөл тус бүрээр тасарсан шалтгааныг судлан, цаашид бүрэн биелүүлэн ажиллах нөхцөл бүрдүүлэх зорилгоор "Татварын бааз суурийг нэмэгдүүлэх, мэдээллийн зөрүүг арилгах" аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулахаар аймгийн Засаг даргын А/240 дугаар захирамжийг батлуулан,</p>	<p>2025.01.01-2025.06.30</p>	<p>-</p>

1	2	3	4	5	6	7	8
					хэрэгжилтийг ханган хэрэгжүүлж байна. 2025 оны сар бүрийн татварын мэдээнд дүн шинжилгээ хийж, гүйцэтгэл бага, тасрах эрсдэлтэй татварын нэр төрлүүдэд онцгой анхаарч, хяналт тавин, шалтгаан нөхцлийг тодруулж, холбогдох сум байгууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна.		
	Дэд арга хэмжээ – 1.1.2: Төсвийн орлого бүрдүүлэгч байгууллагууд болон сумдын саналыг нэгтгэн боловсруулж, төлөвлөгөөнд тусгах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	20%	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 оны төсвийн орлогын төсөл, 2027–2028 оны төсвийн төсөөллийг эдийн засгийн суурь үзүүлэлт, судалгаа, бүртгэл, таамаглал, тооцоололд үндэслэн байгууллага тус бүрээр боловсруулж санал авах зорилгоор аймгийн Засаг даргын 1а/414, 1а/415, 1а/416, 1а/417, 1а/418, 1а/419, 1а/420, 1а/422 дугаар албан бичгүүдийг хүргүүлсэн. Албан бичгүүдийг 20 сум, Татварын хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, Авто тээврийн төв, Монгол банк, Нийгмийн даатгалын хэлтэс, Цагдаагийн газар зэрэг орлогын бүрдүүлэлттэй шууд болон шууд бусаар холбоотой байгууллагуудад хүргүүлж, холбогдох саналуудыг нэгтгэх ажлыг зохион байгуулж байна.	2025.01.01- 2025.06.30	
	Дэд арга хэмжээ – 1.1.3: Төлөвлөгөөний төслийг боловсруулж, Сангийн яаманд хянуулах	Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь	0%	40%	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-д заасны дагуу 2026 оны төсвийн төслийг 7 сарын 25-ны дотор боловсруулан Сангийн яаманд хянуулна.	2025.01.01- 2025.06.30	
	Арга хэмжээ №1.2. Орон нутгийн төсвийн орлогын	Аймгийн 2026 оны төсвийг ИТХ-аар	Аймгийн 2025 оны төсвийг	Аймгийн 2026 оны төсвийг	Аймгийн төсвийн орлогын 2021–2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлд сум бүрээр динамик шинжилгээ хийж, орлогын		

1	2	3	4	5	6	7	8
1	төлөвлөгөөг бүрдүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн санал, орлогын нэр төрөл тус бүрээр олон жилийн динамик судалгаа, холбогдох мэдээлэлд үндэслэн, орлогод нөлөөлөх хүчин зүйлсийг тооцож, үндэслэлтэй боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах	хэлэлцүүлэн батлуулах	ИТХ-ын 4/28 тогтоолоор батлуулсан.	ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан байна.	биелэлтэд нөлөөлсөн гол хүчин зүйлс, шалтгаануудыг тодорхойлсон. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1-д заасанчлан УИХ-аар батлагдсан төсвийн төслийн хүрээнд дараа жилийн төсвийн төслийг боловсруулан 11 сарын 20-ны дотор Төрийн аудитын байгууллагад, 11 сарын 25-ны дотор аймгийн ИТХ-д өргөн мэдүүлнэ.	2025.01.01-2025.06.30	-
3	Арга хэмжээ №1.3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу сар, улирлын хуваарийн төслийг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулах, батлагдсан төсвийн хуваарийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төлөвлөгөөний хамт орлогын хуваарийг эдийн засгийн ангиллаар төсвийн программд шивж оруулах	Төсвийн программд орлогын хуваарийн мэдээлэл оруулсан сумын тоо	20	20	Аймгийн ИТХ-н 2024 оны 12 сарын 20-ны өдрийн 4/28 тогтоолоор батлагдсан төсөв болон сумын ИТХ-н тогтоолыг нэг бүрчлэн тулгаж хянасны үндсэн дээр аймгийн Засаг даргын 2025 оны 1 сарын 17-ны өдрийн А/22 захирамжаар төсвийн орлогын сар улирлын хуваарийг батлуулж, төсвийн төлөвлөлтийн системд татварын орлогын нэр төрөл тус бүрээр шивж, аймгийн Татварын газар болон сумдад хүргүүлэн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100
4.	Арга хэмжээ №1.4. Тайланг оны төсөвт тодотгол хийх тооцооллыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах	Дээд шатны төсөвт тодотгол хийгдсэн тохиолдолд аймгийн тодотголын төслийг боловсруулж, батлуулах	Аймгийн 2024 оны төсвийн тодотголыг ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 16-ний 21/06 тогтоолоор батлуулсан	Тодотголын төслийг аймгийн ИТХ-р батлуулсан байна.	Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дах хэсэгт заасны дагуу дээд шатны байгууллага төсөвт тодотгол хийсныг үндэслэн аймгийн төсөвт тодотгол хийх тооцооллыг боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулна.	2025.01.01-2025.06.30	-

Зорилт 2. "Төсвийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавих, мэргэшил аргазүйн дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд							
1	2	3	4	5	6	7	8
1.	Арга хэмжээ №2.1. Аймаг сумдын төсвийн орлогын гүйцэтгэлийг сар бүр Татварын газартай хамтран хянаж, Сангийн яамны мэдээлэлтэй тулган мэдээний үнэн зөв байдлыг ханган ажиллах	Орлогын гүйцэтгэл зөрүүгүй байх	Орлогыг зөрүүгүй хаасан	Орлогыг зөрүүгүй хаасан байна.	Сар бүрийн төсвийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын газартай хамтран гарган, Сангийн яамны мэдээлэлтэй тулган мэдээний үнэн зөв байдлыг ханган ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сум бүрээр нягтлан дүн шинжилгээ хийж, гүйцэтгэл бага, тасрах эрсдэлтэй татварын нэр төрлүүдэд онцгой анхаарч, хяналт тавин, шалтгаан нөхцлийг тодруулж, холбогдох сум байууллагуудыг арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100
2.	Арга хэмжээ №2.2. Улсын, орон нутгийн татварын болон татварын бус орлогыг цаг хугацаанд нь, нэр төрөл тус бүрээр төвлөрүүлэх	Орлогын гүйцэтгэл /сая.төг/	38,514.0	46,080.4	2025 оны 5 дугаар сарын гүйцэтгэлийн мэдээгээр улсын төсвийн орлогын гүйцэтгэл 114,1 хувь буюу 2,595.3 сая төгрөг, орон нутгийн төсөв 15,296 сая төгрөг буюу 115,8 хувиар биелсэн байна. Улсын болон орон нутгийн татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 18,940.3 сая төгрөг буюу 114,5 хувь биелсэн үзүүлэлттэй байна.	2025.01.01-2025.06.30	100
3.	Арга хэмжээ №2.3. Хөрсний татвар төлөгчдийн мэдээллийн бааз суурийн зөрүүг арилгаж, татварын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх	Орлогын гүйцэтгэл /сая.төг /	2,229.4	5,141.1	5 дугаар сарын байдлаар АТБӨЯХАТатвар 492,273.4 мянган төгрөг буюу 115.8 хувь, газрын төлбөр 266331.3 мянган төгрөг буюу 152.3 хувь, ҮХЭХАТатвар 601,139.2 мянган төгрөг буюу 320 хувь, галт зэвсгийн албан татвар 21,407 мянган төгрөг буюу 892 хувиар давж биелсэн үзүүлэлттэй байна. Нийт дүнгээрээ эхний 5 сарын байдлаар хөрсний орлогын татвараар 1,114,819.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байна. Мөн хөрсний татвар төлөгчдийн мэдээллийн зөрүүг арилгах, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор "Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 155 дахь заалтын хэрэгжилтийг хангах, Аймгийн	2025.01.01-2025.06.30	100

1	2	3	4	5	6	7	8
					<p>Засаг даргын А/279 дугаар “Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, хяналтын ажлыг эрчимжүүлэх тухай” захирамжийг боловсруулан батлуулж, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Татварын газрын дарга, Улсын бүртгэлийн хэлтсийн даргын хамтарсан удирдамжаар ажлын хэсэг байгуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус удирдамжийн хүрээнд 05 дугаар сарын 25-с 27-ны өдрүүдэд Шинэжинст сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Сэкер Ресорсус Монголиа ХХК болон Эрдэнэ Монгол ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж, удирдамжийн дагуу хяналт шалгалт, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>		
4.	<p>Арга хэмжээ №2.4. Сүүлийн 4 жилийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах</p>	<p>Хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоо</p>	-	1	<p>Аймгийн төсвийн орлогын 2021–2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэлд сум бүрээр динамик шинжилгээ хийж, орлогын биелэлтэд нөлөөлсөн гол хүчин зүйлс, шалтгаануудыг тодорхойлсон. Шинжилгээний үр дүнд зарим нэр төрлийн татварын орлого тасралттай байгааг илрүүлж, нэр төрөл тус бүрээр тасарсан шалтгааныг судлан, цаашид бүрэн биелүүлэн ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Татварын бааз суурийг нэмэгдүүлэх, мэдээллийн зөрүүг арилгах” аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулахаар аймгийн Засаг даргын А/240 дугаар захирамжийг батлуулан холбогдох байгууллагууд болон сумдуудтай хамтран хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	2025.01.01-2025.06.30	100
5.	<p>Арга хэмжээ №2.5. Өмнөх оны гүйцэтгэлээр нэр төрлөөр тасарсан</p>	<p>Орлогын гүйцэтгэлийн хувь</p>	-	100	<p>Өнгөрсөн оны татварын орлогын гүйцэтгэлээр нэр төрлөөр тасарсан татварын орлогод дүн шинжилгээ хийж</p>	2025.01.01-2025.06.30	100

1	2	3	4	5	6	7	8
	татварын орлогод дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авах				2025 онд аймгийн Засаг дарга, Сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд татварын орлогын нэр төрөл тус бүрээр биелүүлэх талаар заалт болгон оруулсан. Энэ онд татварын орлогыг нэмэгдүүлэх, батлагдсан "Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө"-г нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлж, татварын орлогын бааз суурийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын А/240, А/279 дугаар захирамжуудын хэрэгжилтийг ханган сар бүрийн татварын орлогын мэдээнд дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авч ажиллаж байна.		
Зорилт 3. " Хууль тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнах, ил тод байдлыг хангаж ажиллах" зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ №3.1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хуулийн хугацаанд байршуулсан мэдээллийн тоо	16	16	Шилэн дансны тухай хуулийн дагуу аймгийн ТЕЗахирагчийн Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээ, төлбөр хураамжийн мэдээлэл, хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт зэрэг мэдээллүүдийг сар бүрийн 08-ны өдрийн дотор шилэн дансны цахим хуудсаар дамжуулан нийтэд ил тод мэдээлэн ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100
2.	Арга хэмжээ №3.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжилтийг тайлагнах	Хэрэгжилтийн тайлагналтийн хувь	-	100	Аймгийн Засаг Даргын А/286 захирамжаар батлагдсан "Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам"-д заасан цаглабарын дагуу сар бүр аймгийн хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100

1	2	3	4	5	6	7	8
3.	Арга хэмжээ №3.3. Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, журмын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	Хөтлөх нэрийн жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн баримтын тоо	2	2	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны архивын 24 баримт, 2025 оны төсвийн төслийн 10 баримтыг үдэж цэгцлэн байгууллагын архивт хүлээлгэн өгсөн.	2025.01.01-2025.06.30	100
4.	Арга хэмжээ №3.4. Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудыг хянан дүн шинжилгээ хийх	Хянасан актын тоо	-	1	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбоотой аймгийн ИТХ-ын 2021 оны 5/18 тогтоолоор батлагдсан "Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай" тогтоолд өөрчлөлт оруулан шинэчлэн боловсруулж батлуулах шаардлага үүссэн. Шинэчлэн батлуулах тогтоолын төслийг бэлтгэсэн ба Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу холбогдох материалыг бүрдүүлэхээр Хууль эрх зүйн хэлтэс, Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн хэлтэстэй хамтран ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	7		
1	2	3	4	5	6	7	8	
1.	"MNS ISO 9001:2016-ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО, ШААРДЛАГА" сургалтад хамрагдах	Гэрчилгээний тоо	0	2	Стандарт хэмжил зүйн газраас зохион байгуулсан "MNS ISO 9001:2016-ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО, ШААРДЛАГА" сэдэвт сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 01,02-ны өдрүүдэд хамрагдан НамТСПЛСТ БХ006/25 дугаар гэрчилгээ, 04 дүгээр сарын 03,04-ний өдрүүдэд "MNS ISO 9001:2016-ЧАНАРЫН	2025.04.01-2025.04.04	100	

1	2	3	4	5	6	7	8
					МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНД АУДИТ ЯВУУЛАХ АРГА ЗҮЙ" сэдэвт сургалтад хамрагдан НамтсЛСТ БХ065/25 "ДОТООД АУДИТОР"-н гэрчилгээг тус тус гардан авсан.		
2.	"UPDATE-2025" чадавхжуулах сургалт зохион байгуулах	Хамрагдсан хүний тоо	0	40	Сумдын төрийн сангийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, албан хаагчдыг чадавхжуулах зорилгоор 20 сумын Санхүү албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтнүүдэд "UPDATE-2025" чадавхжуулах сургалт, арга хэмжээг 05 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд хамтран зохион байгуулсан.	2025.05.01-2025.05.02	100
3.	Хог хаягдлын судалгаа боловсруулах	Судалгааны тоо	0	1	Аймгийн 20 сумын Хог хаягдлын судалгааг боловсруулан хог хаягдлын хураамжын төлбөрийн орлого тасарч буй шалтгааныг тодорхойлж, орлогыг бүрэн төвлөрүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлэн, зохистой арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна.	2025.04.16-2025.05.24	100
4.	"Баянхонгор аймгийн хэмжээнд олгогдсон ашигт малтмалын олборлолт ил тод байдал, гэрээний хэрэгжилт, үр дүн, хяналт" сэдэвт сонголд оролцох	Оролцсон арга хэмжээний тоо	0	1	"Баянхонгор аймгийн хэмжээнд олгогдсон ашигт малтмалын олборлолт ил тод байдал, гэрээний хэрэгжилт, үр дүн, хяналт" сэдэвт ерөнхий сонголын урьдчилсан хэлэлцүүлэгт Татварын газартай хамтран холбогдох мэдээлэл өгч ажилласан.	2025.05.28	100
5.	Төрийн аудитын газраас гаргасан дүгнэлтүүдтэй холбогдох арга хэмжээ авах	Тайлангийн тоо	0	2	Төрийн аудитын газраас ирүүлсэн Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, дүгнэлтүүдийг судалж, төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд хамаарах асуудлуудтай танилцан хийж хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон анхаарч ажиллаж байна.	2025.04.20-2025.05.28	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	
1	2	3	4	5	6	7	8
1.	Арга хэмжээ 1. Үйл ажиллагаандаа олон улсын ISO 9001-2015 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах	Өдөр тутамдаа хэрэгжүүлж ажиллах	-	100%	Аймгийн ЗДТГ-н даргын тушаалаар Дотоод аудитын багт томилогдон дотоод аудитороор ажиллан Төлөвлөлт 6 дугаар бүлгийн хүрээнд гурван дэд бүлэг, таван зүйл заалтын дагуу нийт 20 шалгуур үзүүлэлтээр дотоод аудит хийсэн. Чанарын менежментийн тогтолцоог өдөр тутамдаа хэрэгжүүлэн ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100
2.	Арга хэмжээ 2. Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх	Хамрагдсан сургалтын тоо	-	1	Баянхонгор сумын ЗДТГ, Насан туршийн боловсролын газраас зохион байгуулсан "Үндэсний хэл, соёлын дархлаа" Монгол бичгийн цахим бичвэрийн арга зүй олгох сургалтад хамрагдсан.	2025.01.01-2025.06.30	100
3.	Арга хэмжээ 3. Улсын тэргүүний санхүү, төрийн сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах	Бусад аймгийн СТСХэлтсээс туршлага судлах	-	-	Санхүү, төрийн сангийн хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсны дагуу 3 дугаар улиралд хийгдэнэ.	2025.01.01-2025.06.30	-
4.	Арга хэмжээ 4. Шинээр гарсан тогтоол шийдвэр болон шинээр сурсан аливаа зүйлийг хэлтсийн мэдлэг хуваалцах цагаар бусад мэргэжилтнүүдэд зааж сургах	Мэдээллийн тоо	-	1	Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль болон бусад холбогдох хууль журмуудыг судалсан. Шинээр сурсан мэдлэг ур чадвараа бусдад хуваалцан ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100

1	2	3	4	5	6	7	8
5.	Арга хэмжээ 5. Мэдлэг чадвар эзэмших, хөгжих зорилгоор шаардлагатай, сургалтуудад хамрагдах	Хамрагдсан сургалтын тоо	-	1	Мэдлэг чадвар эзэмших зорилгоор Чанарын менежментийн тогтолцоонд аудит хийх арга зүйн сургалтад хамрагдаж Аудиторын гэрчилгээ гардаж авсан. Монгол Улсын их сургуулийн Бодлогын судалгааны лабораториос зохион байгуулдаг Data analysis Power BI & Excel сургалтад 06 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд суралцахаар төлөвлөсөн.	2025.01.01-2025.06.30	100
6.	Арга хэмжээ 6. Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин хамгаалах, цаг ашиглалтыг нэмэгдүүлэх, стрессийн хүчин зүйлийг зөрөг аргаар даван туулахад суралцах	Ажлын бүтээмж нэмэгдэх	Өдөр тутамдаа	Ажлын бүтээмж нэмэгдсэн байна.	Хууль, журамд нийцүүлэн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллаж байна. Ажлын байрны цаг ашиглалтыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмжээ дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байна.	2025.01.01-2025.06.30	100
7.	Арга хэмжээ 7. Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг чанартай, түргэн шуурхай хэрэгжүүлэх	Ажлын үр дүнг нэмэгдүүлэх	Тухай бүр	Ажлын үр дүнг нэмэгдсэн байна.	Аймгийн Засаг дарга, Тамгын газрын дарга, Нэгжийн даргаас өгсөн хугацаатай болон цаг үеийн шинж чанартай үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажилласан.	2025.01.01-2025.06.30	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ОРЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН

Н. Мартинов

/ Н.ЖАРГАЛМАА /

2025.06.06

**ОРЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН
НАРМАНДАХЫН ЖАРГАЛМААГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	2	3	4	5	6
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Төсвийн орлогын төсөл боловсруулж, төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлэх”					
1.	Арга хэмжээ №1.1. Аймгийн 2026 оны төсвийн орлогын төлөвлөгөөний төслийг боловсруулж, Сангийн яаманд хянуулах	60	10	70	
	Дэд арга хэмжээ – 1.1.1: Татварын нэр төрөл бүрд судалгаа, шинжилгээ хийх	50	10	60	
	Дэд арга хэмжээ – 1.1.2: Төсвийн орлого бүрдүүлэгч байгууллагууд болон сумдын саналыг нэгтгэн боловсруулж, төлөвлөгөөнд тусгах	50	10	60	
	Дэд арга хэмжээ – 1.1.3: Төлөвлөгөөний төслийг боловсруулж, Сангийн яаманд хянуулах	60	10	70	
2.	Арга хэмжээ №1.2. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг орлого бүрдүүлэгч байгууллагуудаас ирүүлсэн санал, орлогын нэр төрөл тус бүрээр олон жилийн динамик судалгаа, холбогдох мэдээлэлд үндэслэн, орлогод нөлөөлөх хүчин зүйлсийг тооцож, үндэслэлтэй боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах	50	5	55	
3.	Арга хэмжээ №1.3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу сар, улирлын хуваарийн төслийг боловсруулан Аймгийн Засаг даргаар батлуулах, батлагдсан төсвийн хуваарийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төлөвлөгөөний хамт орлогын хуваарийг эдийн засгийн ангиллаар төсвийн программд шивж оруулах	60	10	70	
4.	Арга хэмжээ №1.4. Тайлант оны төсөвт тодотгол хийх тооцооллыг	60	10	70	

1	2	3	4	5	6
	боловсруулан аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах				
Зорилт 2. "Төсвийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавих, мэргэшил аргай зүйн дэмжлэг үзүүлэх"					
1.	Арга хэмжээ №2.1. Аймаг сумдын төсвийн орлогын гүйцэтгэлийг сар бүр Татварын газартай хамтран хянаж, Сангийн яамны мэдээлэлтэй тулган мэдээний үнэн зөв байдлыг ханган ажиллах	60	10	70	
2.	Арга хэмжээ №2.2. Улсын, орон нутгийн татварын болон татварын бус орлогыг цаг хугацаанд нь, нэр төрөл тус бүрээр төвлөрүүлэх	50	5	55	
3.	Арга хэмжээ №2.3. Хөрөнгийн татвар төлөгчдийн мэдээллийн бааз суурийн зөрүүг арилгаж, татварын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх	60	5	55	
4.	Арга хэмжээ №2.4. Сүүлийн 4 жилийн орлогын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах	50	5	55	
5.	Арга хэмжээ №2.5. Өмнөх оны гүйцэтгэлээр нэр төрлөөр тасарсан татварын орлогод дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авах	50	8	58	
Зорилт 3. "Хууль тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнах, ил тод байдлыг хангаж ажиллах"					
1.	Арга хэмжээ №3.1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	60	10	70	
2.	Арга хэмжээ №3.2. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжилтийг тайлагнах	60	10	70	
3.	Арга хэмжээ №3.3. Архивын тухай хууль, албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, журмын дагуу хадгаламжийн нэгж бүрдүүлж, байгууллагын архивт хүлээлгэн өгөх	60	10	70	
4.	Арга хэмжээ №3.4. Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудыг хянан дүн шинжилгээ хийх	60	10	70	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1.	"MNS ISO 9001:2016-ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО, ШААРДЛАГА" сургалтад хамрагдах	50	10	60	
2.	"UPDATE-2025" чадавхжуулах сургалт зохион байгуулах	60	10	70	
3.	Баянхонгор аймгийн Сум дундын шүүхэд мэдээлэл гаргаж хүргүүлэх	60	10	70	
4.	Хог хаягдлын судалгаа боловсруулах	60	10	70	
5.	"Баянхонгор аймгийн хэмжээнд олгогдсон ашигт малтмалын олборлолт ил тод байдал, гэрээний хэрэгжилт, үр дүн, хяналт" сэдэвт сонсголд оролцох	60	10	70	
6.	Төрийн аудитын газраас гаргасан тайлан, дүгнэлтүүдтэй танилцаж,	50	10	60	

1	2	3	4	5	6
6.	холбогдох арга хэмжээ авах				
Дундаж оноо:					

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	2	3	4	5
1.	Арга хэмжээ 1. Үйл ажиллагаандаа олон улсын ISO 9001-2015 чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллах		13	
2.	Арга хэмжээ 2. Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх		13	
3.	Арга хэмжээ 3. Улсын тэргүүний санхүү, төрийн сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах		15	
4.	Арга хэмжээ 4. Шинээр гарсан тогтоол шийдвэр болон шинээр сурсан аливаа зүйлийг хэлтсийн мэдлэг хуваалцах цагаар бусад мэргэжилтнүүдэд зааж сургах		15	
5.	Арга хэмжээ 5. Мэдлэг чадвар эзэмших, хөгжих зорилгоор шаардлагатай, сургалтуудад хамрагдах		13	
6.	Арга хэмжээ 6. Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин хамгаалах, цаг ашиглалтыг нэмэгдүүлэх, стрессийн хүчин зүйлийг эерэг аргаар даван туулахад суралцах		15	
7.	Арга хэмжээ 7. Удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийг чанартай, түргэн шуурхай хэрэгжүүлэх		15	
Дундаж оноо			14,1	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	7	
3.	Асуудал шийдвэрлэх	7	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо		7	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8

2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	64,9
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14,1
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	-
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		94%

Үнэлгээ өгсөн:САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

/ С. БАЙГАЛМАА /

2025.06.09 (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН
ОРЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН *Н. Жаргалмаа***Төрийн жинхэнэ албан хаагч:**

/ Н.ЖАРГАЛМАА /

2025.06.06

(огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ажлагч:

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

/ Т.ЭРДЭНЭБАТ /

2025.06.18

(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ХҮНИЙ НӨӨЦИЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

/ Т. САНДАГДОРЖ /

2025-06-18

(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

/ Т.ХИШИГБААТАР /

2025-06-18

(огноо)

